

Сайн байцгаана уу? Хүндэт эцэг эхчүүдээ.

Та бүхэндээ мэдээлэл технологийн багшийн хувиар ухаалаг утасны хэрэглээний талаар баримталж байгаа бодлоо хуваалцах гэсэн юм.

Бид мэдээллийн эрин зуунд амьдарч байна. Бидний өдөр тутмын үйл амьдралыг гар утас, интернет, харилцаа холбооны хэрэгсэлгүйгээр төсөөлөхийн аргагүй болжээ. Дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлага ч үүнийг бэлхнээ харуулж байгаа. Орчин үеийн ухаалаг гар утаснууд нь зураг авах, бичлэг хийх, интернетэд орох, нийгмийн сүлжээг ашиглах, дуу хураах, тооны машин, толь бичиг зэрэг бидний өдөр тутмын амьдралд хэрэгтэй маш олон аппликейшнтэй болжээ. Бидний хүүхдүүд энэ болгоныг хэрэглэж, ашиглаж байна. Энэ нь ч туйлын зөв байх.

Харин гэтэл сүүлийн үед зарим сургууль, эцэг эхчүүдийн санаачилгаар гар утсыг хорих, сургуулийн орчинд интернет хязгаарлах, ухаалаг утсыг ашиглуулахгүй гэх мэт дэглэмийг тогтоож байна. Энэ нь нийгэмд түгэх хандлагатай тэрч байтугай боловсролын байгууллагын удирдах түвшинд хүртэл яригдах янзтай байна. Зарим нэг сургуулиуд ухаалаг утсыг хорьж байна.

Манай сургуулийн хувьд харин суралцагчдаа дэмжих үүднээс үнэгүй, кодгүй WiFi орчныг бүрдүүлж, ухаалаг утсыг хичээлдээ хэрхэн зөв ашиглах талаар суралцагчдын санаа бодлыг сонсон, санаачлага өрнүүлэн ажиллаж байна. Бид монгол хүүхдийг бусад орны хүүхдүүдээс дутахгүйгээр техник технологийн дэвшлийг ашиглаж сурахад бүх анхаарлаа хандуулан ажиллана.

Хүндэт эцэг эхчүүд та бүхэн үр хүүхдэдээ хэрхэн утас ашиглах, интернетийн хэрэглээний талаар өөрсдийн хүүхдүүдтэй санал бодлоо солилцоно гэдэгт найдаж байна.